



Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь



Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь

Тайлан бэлтгэсэн: Монголын Криминологичдын Холбоо

2020 оны 9 дүгээр сар

АНУ-ын Засгийн газраас санхүүжүүлэв.

Энэхүү судалгааг АНУ-ын Төрийн Департментын харьяа Олон улсын хар тамхитай тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагааны товчооны (INL) санхүүгийн дэмжлэгтэйгээр Олон Улсын Хөгжлийн Эрх Зүйн Байгууллагын (IDLO) хэрэгжүүлж буй “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн хүрээнд Монголын Криминологичдын Холбоо хийж гүйцэтгэлээ. Тайланд дурдсан мэдээлэл нь зөвхөн Монголын Криминологичдын Холбооны үзэл бодлыг илэрхийлэх бөгөөд Олон Улсын Хөгжлийн Эрх Зүйн Байгууллага болон АНУ-ын Төрийн Департментын үзэл бодлыг илэрхийлэхгүй болно.



Анхаар: Тайланд дурдсан өгөгдөл мэдээлэл нь тодорхой хязгаарлалт бүхий мэдээлэл болно. 2017 оны эхний 6 сарын мэдээлэл болон 2019 оны сүүлийн 9 сарын мэдээлэл бүрэн хэмжээнд олдоогүй. 2018 оны мэдээллийг судалгаанд бүхлээр нь хамруулсан ч сар тутмын задаргаа бүхий тоон мэдээлэл байхгүйгээс үүдэн тайланд тусгасан тоон мэдээлэл нь хамаарах бүхий л нөхцөл байдлыг бүрэн төлөөлөхгүй бөгөөд боломжит мэдээллийн хүрээнд нөхцөл байдлыг тусган харуулсан болно.

АГУУЛГА

Товчилсон үгс	iv
Лавлах хүснэгт	v
Танилцуулга	1
Гол үр дүн	3
Эрх зүйн орчин.....	4
2004 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, үүний хэрэгжилтэд тулгарсан сорилтууд.....	4
Өнөөгийн эрх зүйн орчин: 2017 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль.....	6
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд (2017) орсон нэмэлт өөрчлөлтүүд	7
Хууль тогтоомжид буй гол орхигдол, хийдэл.....	9
Арга зүй.....	10
Тоон мэдээлэл болон хязгаарлалтууд	12
Чанарын мэдээлэл	13
Хавтас тэргийн дүн шинжилгээ, түүвэрлэлт	13
Фокус бүлгийн хэлэлцүүлэг	15
Үр дүн	17
Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал.....	17
Цагдаагийн газрын хүлээн авсан дуудлага, мэдээллээр илрүүлсэн гэр бүлийн хүчирхийлэл.....	17
Зөрчлийн хэрэг	20
Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг.....	22
Кейс (хэргийн) судалгаа: Фокус бүлгийн хэлэлцүүлэг болон хавтас тэргийн шинжилгээ – Хуулийн хэрэгжилтэд гарч буй орхигдол, хийдэл	30
Хууль тогтоомжийн талаарх ойлголт, мэдлэгт тулгарч буй асуудлууд.....	30
Зөрчил болон гэмт хэрэг.....	31
Мердэн байцаалтын үйл ажиллагаанд тулгарч буй саад тогторууд.....	31
Хэрэг хэрэгсэхгүй болгох	32
Ногдуулж буй ял	34
Дүгнэлт, зөвлөмжүүд	37
Ном зүй	41

ТОВЧИЛСОН УГС

ЭХ	Эрүүгийн хууль
ШШГГ	Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газар
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ФБХ	Фокус бүлгийн хүчирхийлэл
ЖСХ	Жендерт суурилсан хүчирхийлэл
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
ҮЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын Газар
ШЕЗ	Шүүхийн Ерөнхий Зөвлөл
ГБХТТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай
МКХ	Монголын Криминологичдын Холбоо
МНТ	Монгол төгрөг
ХЭДХЯНА	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам
ТББ	Төрийн бус байгууллага
ЗХ	Зөрчлийн тухай хууль
НҮБХАС	НҮБ-ын Хүн Амын Сан
\$	ам.доллар
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЛАВЛАХ ХҮСНЭГТ

Хүснэгт 1: Сонгон авч, шинжилгээ хийсэн хэргүүд, нийслэлийн дүүргээр	14
Хүснэгт 2: Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийлэл, 2014-2018	17
Хүснэгт 3: Цагдаагийн байгууллагын хүлээн авч буй гэмт хэрэг, зөрчлийн дуудлагын дундаж тоо, сараар, жил тутмын сарын дундаж.....	19
Хүснэгт 4: Нийслэл Улаанбаатар болон дүүргүүд дэх дуудлага мэдээллийн дундаж тоо, жил тутмын сарын дундаж	19
Хүснэгт 5: Зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэлт.....	25
Хүснэгт 6: Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн хэрэг, нийслэл болон аймгууд, 2017-2019	25
Хүснэгт 7: Гэмт хэрэг, хот болон хөдөө, оноор	26
Хүснэгт 8: Гэмт хэрэг үйлдэгдэж буй байршил, оноор	28
Хүснэгт 9: Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг зүйлчлэл (ангилал).....	29
Хүснэгт 10: Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн хохирогчид, нас болон хүйсээр.....	30

ТАНИЛЦУУЛГА

2017 онд хийсэн судалгаагаар 15-64 насны Монгол эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (57.9%) нэг эсвэл үүнээс дээш хэлбэрийн гэр бүлийн хүчирхийлэлд (бие маҳбодын, бэлгийн, сэтгэл санааны болон эдийн засгийн) өртөж буйг тогтоожээ.¹ Монгол эмэгтэйчүүдийн ойролцоогоор 31.2% нь амьдралдаа бие маҳбодын болон бэлгийн хүчирхийлэлд ямар нэгэн байдлаар өртөж байсан бөгөөд эмэгтэйчүүд бие маҳбодын болон/эсвэл бэлгийн хамтрагчийн хүчирхийлэлд өртөж буй тоо нь Дархан-Уул (41.0%), Өмнөговь (39.7%), Говьсүмбэр (39.1%), Булган (35.7%), Ховд (32.9%) аймгуудад хамгийн өндер байна. Хамтрагчийн үйлдсэн гэр бүлийн хүчирхийллийн нэг эсвэл дээш тооны хэлбэрт өртөж байсан эмэгтэйчүүдийн хувь хэмжээ нь аймгуудын хувьд 68.6%- 36.0%-ийн хооронд хэлбэлзэж байна.²

Энэхүү судалгаа нь иргэд гэр бүлийн хүчирхийллийн талаарх дуудлага, мэдээлэл өгөхдөө хууль хяналтын байгууллагуудад итгэх итгэл бага, хамтрагчийнхаа үйлдсэн бие маҳбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн 10 эмэгтэй тутмын 1 хүрэхгүй нь л (8.3%) тухайн хэргийн талаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж буйг тогтоосон. Эмэгтэйчүүдийн гуравны нэгээс илүү хувь нь хүчирхийллийн тохиолдлын талаар өөрийн найз нөхөд, гэр бүл эсвэл хамтрагчийн гэр бүлд итгэж хэлдэг байна. Хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн зүгээс гэр бүлийн хүчирхийллийн талаар цагдаа, эмнэлэг, шашны байгууллагын төлөөлөл эсвэл төрийн бус байгууллага (ТББ), эмэгтэйчүүдийн байгууллагад мэдэгдэлгүйгээр (аль алинд нь 3.0%) хэнд ч хэлэхгүй нуухыг (23.5%) илүүд үздэг нь Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийллийн цар хүрээг нарийн тооцоолон гаргахад хүндэрэл учруулж байна.³

Гэр бүлийн хүчирхийллийн цөөн тохиолдлууд л ил болж, үүнээс мөн л цөөн тохиолдлыг хууль сахиулах эрх бүхий байгууллагад мэдээлж буйн улмаас

¹ НҮБ-ын Хүн Амын Сан, 2017 Монгол Улс дахь жендерт сууринсан хүчирхийллийн талаарх үндэсний судалгаа (Улаанбаатар: НҮБ-ын Хүн Амын Сан болон Үндэсний Статистикийн Хороо, 2018), 13.

² Мөн тэнд, 61.

³ Мөн тэнд, 105.

цагдаа, шүүхийн гаргаж буй статистик мэдээлэл нь Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийлийн цар хүрээг бүрэн тусгаж чадахгүй байна.⁴ Монгол Улсын иргэдийн 80 хүртэл хувь нь гэр бүлийн хүчирхийлийг тулгараад буй ноцтой асуудал хэмээн үзэж буй ч шүүхийн зүгээс энэ асуудлыг гэр бүлийн дотоод асуудал хэмээн үзсээр иржээ.⁵ Гэр бүлийн хүчирхийлийн үзэгдэл нь олон нийтийн эрх зүйн мэдлэг бага, хохирогчид үзүүлэх үйлчилгээ хангалтгүй, хүртээмж хязгаарлагдмал, сүл хөгжсен бүйтэй хамааралтай байна. Эмэгтэйчүүдийг хамгаалах арга хэмжээг тэгш эрх бүхий иргэн гэхээс илүүтэйгээр ээж, эх хэмээх хандлагад төвлөрүүлж буй албан ёсны жендерийн тэгш байдлын хандлага нь тэдний эмээг, өртөмтгий байдлыг улам нэмэгдүүлсээр иржээ.⁶ Үүнээс үүдэн эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжуудыг хязгаарласан хэвээр байна.

Монголын Криминологичдын Холбооны (МКХ) зүгээс 2018 оны 7 дугаар сараас 2019 оны 5 дугаар сарын хооронд хийсэн энэхүү судалгаа нь Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийлийн талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулахад хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна. Тус судалгаа нь хаваст хэргийн материал, цагдаагийн байгууллагын мэдээлэл, даван туулагчдын мэдүүлэгт хийсэн шинжилгээ, фокус бүлгийн хэлэлцүүлэг, зорилтот ярилцлагыг ашиглан 2017 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд тулгарч буй асуудлууд, орхигдол хийдлийг тодорхойлон гаргасан.⁷ Энэхүү тайланд дурдсан үр дүн, зөвлөмжүүд нь Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийлийн эсрэг хариу арга хэмжээг сайжруулахад хувь нэмэр оруулна хэмээн итгэж байна.

⁴ Бэгзсүрэнгийн Цолモン, Вероника Мендиизабал Жоффре. "Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн дуу хоолойг үйл ажиллагаа болгох нь: Дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх замаар жендерт сууриссан хүчирхийлэлтэй тэмцэх нь." Азийн Хөгжлийн Банкны Зүүн Азийн судалгааны цуврал, дугаар 14 (2018 оны 10 дугаар сар):3.

⁵ Мөн тэнд, 5.

⁶ Хүний Эрхийн Төлөө Өмгөөлөгчид, Хүчирхийлийн Эсрэг Үндэсний Төв, 2016, "Гэр бүлийн хүчирхийлийн талаарх параллель тайлан", 2, Дараах холбоосоор үзнэ үү:

https://www.theadvocatesforhumanrights.org/uploads/mongolia_cedaw_tahr_ncav_january_2016.pdf

⁷ 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт нь 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж өхэлсэн. Энэхүү судалгааны зориулалтаар судлаачид энэхүү хуулийн хэрэгжилтийг авч үзсэн тулд 2017 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэмээн томьёолон дурдсан.

ГОЛ ҮР ДҮН

- Хууль заасан “хүчирхийлэл байнга үйлдэх” шинж/бүрэлдэхүүн нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын хуулийн хүрээнд хамгаалуулах эрхийг зөрчиж, хэрэг мөрдөн шалгах, яллах үйл ажиллагаанд хүндрэлд учруулж байна. Хаваст хэргүүдэд (60 хэрэгт) хийсэн шинжилгээгээр “байнга үйлдэх” гэсэн шинжийг буруу ашиглах боломжгүй эсвэл буруу ойлгож буйгаас үүдэн бүгд 100% зөрчил хэмээн буруу зүйлчлэгдсэн болохыг тогтоосон.
- Судалгааны хамрах хугацаанд нийт зөрчлийн **68%**, гэмт хэргийн **34%-ийг** хэрэгсэхгүй болгосон ба гол үндэслэл нь гэмт хэргийн шинжгүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэсэн үндэслэл байна.
- Хууль сахиулах байгууллагын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлгээр Зөрчлийн тухай хуульд заасан **гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хамрагдах албадан сургалт нь үр дүн багатай, бүрэн хийгдэхгүй** буйг тодорхойлсон бөгөөд энэхүү сургалт бүрэн хийгдсэн ямарваа баримт байхгүйг тогтоосон.
- 2017 оны 2 дугаар сараас эхлэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжиж, гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн гэмт хэрэг хэмээн тооцож эхэлснээс хойш **гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг** буурч, негөө талаар зөрчлийн хэрэг ихээхэн нэмэгджээ. Судалгааны хамрах хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн 33,000 гаруй тохиолдол бүртгэгдсэнээс 95% нь зөрчил хэмээн тооцогдсон байна. Хаваст хэргүүдэд хийсэн шинжилгээ нь шинэчилсэн хуулиудын талаар мэдлэг дутмаг буйгаас шалгаалан буруу зүйлчилж буйг харуулж байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлын 84% нь Улаанбаатар хотод үйлдэгджээ.** НҮБ-ын ХАС-гаас 2017 онд хийсэн судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлын тоо хот болон хөдөө орон нутагт томоохон ялгаагүй буйг тогтоосон ч криминологийн шинжилгээгээр гэр бүлийн хүчирхийллийн гомдлыг хүлээн авч хэрэг үүсгэх, мөрдөн шалгах нөөц болон чадавх нь хот суурин газруудад илүү буйг тогтоосон.⁸

⁸ НҮБ-ын Хүн Амын Сан, 2017 Монгол Улс дахь жендерт сууринсан хүчирхийллийн талаарх үндэсний судалгаа (Улаанбаатар: НҮБ-ын Хүн Амын Сан болон Үндэсний Статистикийн Хороо, 2018), 41.

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2004 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, үүнд тулгарч буй сорилтууд

Монгол Улс нь хамгийн анх Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд батлан хэрэгжүүлж эхэлжээ. Энэхүү хуулийг батлан гаргасан нь тулгараад буй энэхүү асуудлыг албан ёсоор хүлээн зөвшөөрснийг тод томруун харуулсан ч хуулийн хэрэгжилттэй холбоотой олон тооны сорилт, хүндрэл бэрхшээл тулгарсаар байна. Хуулийн талаар олон нийтийн мэдлэг тааруу буйн зэрэгцээ хууль зүйн салбарын оролцогч талууд, үйлчилгээ ханган нийлүүлэгчид нь гэр бүлийн хүчирхийллийн динамик эрчмийн талаарх ойлголт хомс буй хосолмол асуудлууд нь хуулийн үр дүнтэй хэрэгжилтийг сааруулж байна.⁹

2004 оны хуулийн нэг томоохон дутагдалтай тал нь гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг хэмээн шууд тодорхойлоогүй нь хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэхэд хүндрэл үүсгэж байв. Тиймээс ноцтой бус, хөнгөн хэргийг ихэнхдээ архидан согтуурсан эсвэл танхайрсан хэрэг хэмээн бүртгэж байсан бол илүү ноцтой, хүнд хэргүүдийг бусдын эрүүл мэндэд халдсан, бие махбодод гэмтэл учруулсан гэх зэргээр гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг харгалзалгүй бүртгэн, зүйлчилж иржээ. Талууд эвлэрсэн эсвэл хохирогч гомдоо буцаан татсан зэрэг үндэслэлээр ихэнх тохиолдолд хэрэг хаагдаж байжээ.¹⁰

2004 оны хуулиар гэр бүлийн хүчирхийллийг нотлох үүрэг нь хохирогчид ногдож байв. Хохирогчид өөрсдөө шүүх эмнэлгийн шинжилгээнд

⁹ Бэгзсүрэнгийн Цолмон, Вероника Мендиизабал Жоффре. "Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн дуу хоолойг үйл ажиллагаа болгох нь: Дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх замаар жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь." 4.

¹⁰ НҮБ-ын Хүн Амын Сан, 2017 Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийллийн талаарх үндэсний судалгаа (Улаанбаатар: НҮБ-ын Хүн Амын Сан болон Үндэсний Статистикийн Хороо, 2018), 41.

хамрагдаж, дунд эсвэл хүнд гэмтэл учирсан болохоо дүгнэлтээр нотолсноор Эрүүгийн хуулийн дагуу хэрэг үүсгүүлж, мөрдөн байцаах, яллах ажиллагааг явуулах боломжтой байв.¹¹ Шүүх эмнэлгийн дүгнэлт авахын тулд хохирогч нь хол замыг туулан, шүүх эмнэлгийн үзлэгийн төлбөрийг хувиасаа төлөх шаардлагатай байжээ. Холбон зуучлалд тавигдах шаардлагууд өндөр, ажлын цаг хязгаартай нь энэхүү гэр бүлийн хүчирхийлэлтэй хийх тэмцлийг улам төвөгтэй болгож байв. 2004 оны хуульд мөн гомдол гаргагч заавал нотлох шаардлагагүйгээр, иргэний хувьд эрх хасах шийдвэр гаргуулах хүсэлт гаргаж болох чухал заалт багтсан байв. Гэсэн ч шүүгч захирамж гаргахаас өмнө хуулиар заавал хийгдсэн байхыг шаардаагүй аюулын зэргийн үнэлгээг хийсэн байхыг шаардаж байжээ.¹² Аюулын зэргийн үнэлгээг цагдаагийн ажилтан болон нийгмийн ажилтан хамтран хийх ёстай байдаг нь нэмэлт саад тогтор учруулж, тухайн албаны хүмүүс ажлаа сайтар уялдуулан зохицуулж чадаагүй тохиолдолд хохирогчид нэмэлт саад тогтор учруулж байв.

Тулгараад буй бүтцийн болон процедурын хүндрэлүүдээ даван туулж, аюулгүй байдлаа хамгаалуулах тогтоолыг хохирогчийн зүгээс гаргуулж чадсан ч тогтоолын хэрэгжилтийг үр дүнтэйгээр хангахад хуульд буй цоорхой цаашид үргэлжлэн саад тогтор учруулсаар байжээ. Эдгээр цоорхойн тоонд шүүхийн тогтоол хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн эрх бүхий байгууллага байхгүй, тухайн тогтоолыг зэрчсөн тохиолдолд үүсэх үр дагаврыг заасан хуулийн заалт дутмаг буй зэрэг асуудлууд багтжээ.¹³

¹¹ Хүний Эрхийн Төлөө Өмгөөлөгчид, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв. Эмэгтэйчүүдийн алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хорооны 63 дугаар хуралдаанд илгээсэн тайлан. х.4:

https://www.theadvocatesforhumanrights.org/uploads/mongolia_cedaw_loi_june_2015.pdf

¹² Мөн тэнд.

¹³ Мөн тэнд, Бүлэг D, мөр 6-7.

Өнөөгийн эрх зүйн орчин: 2017 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

2004 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн сүл талуудыг засах зорилгоор Монгол Улс нь 2016 оны 12 дугаар тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргасан.¹⁴ 2017 оны 2 дугаар сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн энэхүү нэмэлт өөрчлөлтөөр гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг хэмээн зүйлчлэх болсон бөгөөд үүнд байнга мөшгөн мөрдөх, заналхийлэх зэргийг эрүүгийн зүйлчлэлд оруулан, хамаарах тодорхойлолтуудыг өргөтгөх замаар хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг илүү өргөжүүлжээ. Тус хуулиар гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагч, асран хамгаалагч, үрчлэн авсан хүүхэд, эцэг эх, салсан хосууд болон хамтрагчид зэргийг хуульд багтаан заасан байна. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр 2004 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд хамрагдаагүй хохирогчдын аюулгүй байдлыг хамгаалах олон тооны арга замыг заан өгчээ. Түүнчлэн сургалт хийх, хамгаалах байр ажиллуулах чиглэлээр ТББ-уудад магадлан итгэмжлэл олгож, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг гэр бүлийн хүчирхийллийн даван туулагчид, гэрчүүд дээр авч хэрэгжүүлэх цар хүрээг өргөжүүлжээ.¹⁵ Гэр бүлийн хүчирхийллийн тодорхойлолтыг илүү өргөжүүлэн, сэтгэл санааны, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийллийг хүлээн зөвшөөрч, хуульд тусгажээ.

¹⁴ Венди Зелдин. "Монгол Улс: Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох нь." Олон улсын эрх зүйн монитор (Конгрессын номын сан), 2017 оны 4 дүгээр сарын 12: [https://www.loc.gov/law/foreign-news/article/mongolia-domestic-violence-made-a-criminal-offense/#:~:text=12%2C%202017\)%20On%20February%201,September%201%20of%20that%20year](https://www.loc.gov/law/foreign-news/article/mongolia-domestic-violence-made-a-criminal-offense/#:~:text=12%2C%202017)%20On%20February%201,September%201%20of%20that%20year).

¹⁵ Бэгзсүрэнгийн Цолモン, Вероника Мендизабал Жоффре. "Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн дуу хоолойг үйл ажиллагаа болгох нь: Дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх замаар жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь." 4.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн (2017) нэмэлт өөрчлөлтүүд

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжид буй цоорхой, орхигдлуудыг нөхөх зорилгоор шинээр гарсан хуультай нийцүүлэн нийт зургаан хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Эдгээр хуулиуд нь Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль, Тахарын албаны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчлийн тухай хууль байна.¹⁶ Эдгээр хуульд доор дурдсан гол нэмэлт өөрчлөлтүүдийг хийжээ:

Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг зөрчил (гэмт хэрэг бус) хэмээн тооцдог бөгөөд үүнд "байнга, давтан" хэмээх шинж чанар хамаарахгүй байхаар заажээ:

5.4 дүгээр зүйл, Заалт 4: "Гэр бүлийн хамаарах бүхий харилцаатай хүнийг зодсон; албадсан; даган мөрдсөн; айлан сүрдүүлсэн; нэр төрийг нь гутаасан; хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; хуваарын болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж, 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна."

Одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй **Эрүүгийн хууль** нь "байнга" хүчирхийлэл үйлдэх бүрэлдэхүүнийг багтааж, аргагүй хамгаалалтыг хүлээн зөвшөөрч, өширхсөн/цочирдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн хохирогчид ногдуулах хүнд шийтгэлийг/ялыг хассан байна.¹⁷

¹⁶ Лила Сейдман. "Монгол Улсын Их Хурал гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн гэмт хэрэгт тооцон хуульчиллаа." The UB Post, 2016 оны 6 дугаар сарын 16. <https://web.archive.org/web/20170422024344/http://theubpost.mn/2016/06/16/mongolian-parliament-recognizes-domestic-violence-as-a-criminal-offense/>.

¹⁷ Мөн тэнд.

11 дүгээр бүлгийн 7 дугаар зүйл, Заалт 1: "Гэр бүлийн хамаарах бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарыт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол 6 сараас 1 жил хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

11 дүгээр бүлгийн 7 дугаар зүйл, Заалт 2: "Энэ гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн бол 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 2 жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хэрэв үйлдсэн этгээд нь асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан бол таслан зогсоох гэсэн хүний эсэргүүцэж үйлдсэн бол 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 2 жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

Гэр бүлийн харилцаатай хүнийг алах, бие махбодын гэмтэл учруулах болон хүчиндэх зэргийг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг хэмээн тооцож, гэр бүлийн гишүүний эсрэг үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл хэмээн үзжээ:

10 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл, Заалт 2.8: Тухайн заалтад заасан хэргийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алсан бол хүндрүүлэх нөхцөлд тооцно.

11 дүгээр бүлгийн 1, 4 болон 6 дугаар зүйл: Учуулсан хохирлыг хүнд, хүндэвтэр, хөнгөн хэмээн гурван шатанд хувааж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд хүндрүүлэх нөхцөл хэмээн тооцсон.

12 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл, Заалт 2.3: дээр гэр бүлийн хүнийг хүчиндэх хэргийг гэмт хэрэг хэмээн тооцсон. Гэр бүлийн хүн, салсан гэр бүлийн гишүүн эсвэл хамтрагч үйлдэх тохиолдолд хүндрүүлэх нөхцөлд тооцно. Хүчиндэх гэдгийг бэлгийн болон бэлгийн бус замаар хэмээн ангилан үзсэн.

Өмнө хүчин төгөлдөр хэрэгжиж байсан **Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд** хохирогч болон холбогдогч/яллагдагч эвлэрсэн тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгохоор заасан байв (25.1 дүгээр зүйл). Шинэчлэн найруулсан хуулиар энэхүү заалтыг хүчингүй болгосон ба энэ нь хохирогч өөрийн гомдлоо буцаан татсан ч прокурор уг хэргийг үргэлжлүүлэн хянан шийдвэрлэнэ хэмээх утга агуулж байна.¹⁸

Хууль тогтоомжид буй гол орхигдол хийдэл

Дээр дурдсан зарим чиглэлээр хууль тогтоомж сайжирсан ч хийдэл мөн байсаар байна. Шинэчлэн найруулсан хууль нь өмнөх хуулиас илүү серег үр дагавар, хор хөнөөл ихтэй шинэ зүйл, заалтуудыг зарим тохиолдолд багтаажээ. Жишээ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар (13 дугаар бүлэг) гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авахын тулд эрүүгийн хэрэг үүссэн байхыг шаардаж буй бол өмнөх хуулийн заалтаар эрүүгийн хэрэг үүсээгүй байхад ч хохирогч нь аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээнд хамрагдах боломжтой байжээ.

Эрүүгийн хуульд (11.7 дугаар зүйл) заасан “давтан” (байнга) үйлдсэн гэмт хэргийн шинжийг гэмт хэрэг үйлдсэн хэмээн тооцоогоос өмнө давтан үйлдсэн гэр бүлийн хүчирхийллийн үйлдэл хэмээн тайлбарлаж байна. Улмаар энэхүү тайлбарыг Эрүүгийн хуулийн 120.1 болон 120.2 дугаар заалт улам баталгаажуулснаар гэр бүлийн хүчирхийлэл анх удаа үйлдсэн тохиолдолд торгох, анхааруулах шийтгэл ногдуулах болжээ. Гэр бүлийн хүчирхийлэл хэмээн тооцогдох үйлдлийг байнга үйлдсэн, энэ нь нотлогдсон тохиолдолд л гэмт хэрэг хэмээн тооцогдож, зохих арга хэмжээг (жишээ нь цагдан хорих) авч байна. Хоёр дахь удаагийн үйлдэл нь цагдаад өгсөн хоёр дахь дуудлага эсвэл хоёр дахь шүүхийн шийдвэрээр тодорхойлогдох уу гэдэг нь өнөөг хүртэл тодорхойгүй байна.

¹⁸ УИХ, “Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,” <https://www.legalinfo.mn/law/details/12694> 2017 оны 5 сарын 18, ЭЗХАХБ (OECD), “Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,” 2001 оны 1 дүгээр сарын 10, <https://www.oecd.org/site/adboecdanti-corruptioninitiative/46816723.pdf>.

АРГА ЗҮЙ

Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гаралт болон шалтгаант хүчин зүйлсийг олж тогтоох чиглэлээр өмнө хэд хэдэн судалгаа хийгдсэн ч эдгээрийн аль нь ч нэмэлт өөрчлөлт хийгдсэн хууль болон хамаарах Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хууль зэрэг хууль, тогтоомжуудын хэрэгжилтэд мониторинг хийгээгүй байна. Энэхүү судалгаа нь доор дурдсан үндсэн хөтөч асуултуудын хүрээнд хийгдсэн:

- Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох болсныг статистик мэдээлэлд хэрхэн тусгаж байна вэ? Нийт хэдэн тохиолдол зөрчлийн хэрэг хэмээн бүртгэгдэж байна вэ? Хэдэн тохиолдол гэмт хэрэг хэмээн бүртгэгдэж байна вэ?
- Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг мөрдөн шалгасны дараа хэдэн хэргийг гэмт хэрэг хэмээн зүйлчилж, хэдэн хэрэгт нь зөрчлийн зүйл ангиар шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна вэ? Хэдэн хэргийг, ямар үндэслэлээр хэрэгсэхгүй болгож байна вэ?
- Прокурор дээр бүртгэгдсэн хэргүүдийн хэд нь дараа дараагийн шатандаа шийдэгдэж байна вэ?
- Нэмэлт өөрчлөлт хийгдсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд хууль зүйн салбарт ямар сорилтууд тулгарч байна вэ?

Тус судалгаа нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй сорилтуудыг тодорхойлж, бодлого боловсруулагчид болон бусад хамаарах талуудад гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, тэмцэх зөв зохистой стратеги, үр дүнтэй арга хэмжээг тодорхойлоход дэмжлэг болох юм.

Энэхүү судалгааны хүрээнд дараах зорилтуудыг тодорхойлсон:

1. Нэмэлт өөрчлөлт хийгдсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх

- тухай хууль (2017), Эрүүгийн хууль (2015) болон Зөрчлийн тухай хууль (2017) батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчилд статистик дүн шинжилгээ хийх;
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр шинээр батлагдан хэрэгжиж буй хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хууль зүйн салбарт тулгарч буй асуудлуудыг тодорхойлох;
 3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид, хохирогчдын хүн ам зүйн мэдээллийг тодорхойлох гаргах; болон
 4. Шинэ хуулийн хэрэгжилтийг сайжруулахад дэмжлэг болохуйц зөвлөмжүүдийг бэлтгэн гаргах.

Энэхүү судалгаанд олон төрлийн арга зүйг хослуулан ашигласан бөгөөд тоон болон чанарын мэдээллийг фокус бүлгийн хэлэлцүүлэг, хэргийн материалтай танилцах, 2017 оны 7 сарын 1- 2019 оны 3 сарын 31-ны хооронд цагдаагийн байгууллагаас гаргасан гэр бүлийн хүчирхийллийн хэргийн талаарх албан ёсны статистик зэрэг эх сурвалжаас цуглуулан ашигласан. Тайланд дурдагдсан статистик мэдээлэл нь тусгайлан заагаагүй бол дээр дурдсан хугацаанд хамаарна.

Энэхүү судалгаанд тоон болон чанарын судалгааны арга зүйг хослуулан ашигласан. Монголын Криминологчдын Холбоо нь төрийн байгууллагууд болох Цагдаагийн Ерөнхий Газар, Улсын Ерөнхий Прокурорын Газар, Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газар зэрэг байгууллагуудаас мэдээлэл цуглуулан ашигласан. 2016 онд хууль батлагдаж, 2017 оноос хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш дээрх байгууллага болгон өөрийн мэдээлэл цуглуулах арга зүйгээ шинэчилсэн байна.¹⁹ Цагдаагийн бүх газар, хэлтсүүдийн мэдээллийг

¹⁹ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн талаар цагдаагийн байгууллага нь статистик мэдээллийг ҮСХ-ны Даргын баталсан “Гэмт хэргийн статистик мэдээллийн бүртгэлийн” журмын дагуу бүртгэдэг. Шийдэгдсэн гэмт хэргийн талаар прокурорын байгууллагын статистик мэдээллийн системийг Ерөнхий Прокурорын 2017 оны А/89 тоот тушаалын дагуу ажиллуулдаг.

нэгтгэдэг Цагдаагийн Ерөнхий Газрын Судалгааны төвөөс мэдээлэл авч, давхардсан болон дутуу мэдээллийг харгалзан судалгаанд хэрэглэсэн. Эрүүгийн болон зөрчлийн хаваст хэргийг судлахын тулд чанарын судалгааны аргыг мөн ашигласан. Түүнчлэн хагас албан бус ярилцлагыг хууль сахиулах байгууллагын ажилтнуудтай (хэрэг бүртгэгч, мөрдөгч болон прокурор) хийсэн.

Тоон өгөгдөл болон хамаарах хязгаарлалтууд

Мэдээлэл цуглуулах явцад гэр бүлийн хүчирхийллийн тоо баримт, бүртгэлийг ихээхэн төвлөрсөн бус байдлаар хийж буй нь хамааралтай, үнэн зөв, бодит мэдээллийг цаг хугацаанд нь цуглуулахад томоохон саад тогтор учруулж буйг судлаачид тогтоосон. Хамгийн гол саад бэрхшээл нь мэдээллийн хүртээмж дээр үүсэж буй бөгөөд зарим мэдээллийг зөвхөн тусгайлан зөвшөөрөл авсны үндсэн дээр нийтэд мэдээлж болохоор хуульчлагдсан тул энэхүү судалгаанд зориулан зөвшөөрөл авах шаардлага үүссэн. Ихэнх тохиолдолд хэргүүдийг ялаар нь ангилаагүй байсан. Тайланд дурдсан мэдээлэл нь 4 байгууллагын 4 өөр мэдээллийн сан/эх үүсвэрээс авсан мэдээлэл болно. Тиймээс хэргийн мэдээллийг цагдаа, прокурор, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авсан ба эдгэр байгууллагууд нь ижил арга зүй ашигладаггүй, ижил тодорхойлолт баримталдаггүй, ижил байдлаар ангилан задалдаггүй тул харьцуулан судлах тохиолдолд бүрэн бус мэдээлэл өгөх боломжтой юм. Үүний улмаас энэхүү тайланд бүхий л боломжит мэдээллийг ашигласан ч харуулсан бүх тоон мэдээллийг абсолют хүчин төгөлдөр мэдээлэл хэмээн үзэж болохгүй.

Хэргийн талаарх шүүхийн статистик мэдээлэл нь Давж заалдах шатны шүүхийн шүүхийн статистик, тайлан мэдээний журмын (Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 17 тоот тушаалаар батлагдсан) дагуу зохицуулагдана. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн А/16 тоот тогтоолын дагуу, 2016 оны А/30 тоот тогтоолоор батлагдсан “Статистик мэдээллийн сан болон бүртгэлийн нэгдсэн дугаарлалтын журмын” дагуу шийдвэр гүйцэтгэлийн бүртгэлийг хийдэг.

Цагдаагийн газарт ирүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн статистикийг МКХ авч, STATA программ дээр боловсруулан, дараах мэдээллийг бэлтгэн гаргасан:

- a) Дуудлага, мэдээллээр хүлээн авсан гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо (засаг захиргааны нэгжээр задлан харуулсан)
- b) Хүчирхийлэл үйлдэгчийн тухай мэдээлэл (нас, хүйс болон боловсролын түвшнээр задлан харуулсан)
- c) Хохирогчийн тухай мэдээлэл (нас, хүйс, боловсролын түвшин, гэмтэл, учирсан хохирлоор нь задлан харуулсан)
- d) Гэмт хэрэг болон зөрчилд ногдуулсан шийтгэл (ялын хэмжээ, ангиллаар нь задлан харуулсан)

Чанарын өгөгдөл мэдээлэл

Хаваст хэргийн шинжилгээ, түүвэрлэлт

ҮЕПГ дээр хэрэг үүсгэсний дараа зөрчил, гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэж буйг тогтоохын тулд хаваст хэргийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Хэрэг шийдвэрлэлт болон мөрдөн байцаалт хэрхэн явагддаг талаар тодруулах зорилго бүхий 15 асуулттайгаар боловсруулсан судалгааны хоёр аргачлалыг энэхүү зорилгоор ашигласан. Тухайн асуултууд, арга зүй, хэрэглэгдэхүүнийг боловсруулахдаа гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээр туршлагажсан прокуроруудтай зөвлөлдөхийн зэрэгцээ криминологийн бусад төрлийн судалгаа, хаваст хэргүүдийн шинжилгээнд үндэслэн бэлтгэсэн.²⁰ Судалгааны багт зориулан судалгааны арга зүйг хавтас хэргийн шинжилгээнд хэрхэн ашиглах талаар 8 цагийн сургалт хийсэн. Судлаач бүрд хөтөч асуултуудыг ашиглан мэдээлэл цуглуулах талаар зааварчилгаа өгч, мөрдөн байцаалт, гэр бүлийн хүчирхийллийн хэрэг шийдвэрлэлт дэх дутагдалтай талуудыг хэрхэн тодорхойлох талаар зөвлөгөө өгсөн.

²⁰ Нийт 8 прокурорын саналыг авсан. Эдгээр прокурорууд нь энэхүү дэд төслийг дэмжин хэрэгжиж буй төслийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан прокурорууд байсан.

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл нь Улаанбаатар хотод хамгийн ноцтой хэмжээнд байдаг тул судалгааны баг нь нийслэлийн зургаан дүүрэгт төвлөрөн ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл хэмээн зүйлчлэгдэж, шийдэгдсэн нийт 234 хэргийг тусгайлан сонгон авч, дүн шинжилгээ хийв.²¹ Эдгээр хэргүүдээс 110 нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, 60 хэрэг нь зөрчил хэмээн зүйлчлэгдэж, 64 хэргийг хэрэгсэхгүй болгожээ. 2017 оноос Эрүүгийн хуулийн хүчин төгөлдөр мөрдөгджээхэлснээс хойш 2019 оны 3 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл гэр бүлийн хүчирхийллийн нийт 700 хэрэгт ял ногдуулсны гуравны нэг энэхүү судалгаанд хамрагдсан (234). Хүснэгт 1 дээр хэргийн тархалт нь дүүрэг бүрээр ерөнхийдөө тэгш, шинжилгээнд эрүүгийн гэмт хэрэгт тулхүү анхаарал хандуулсныг (хэрэгсэхгүй болгосон болон зөрчлийн хэрэгтэй харьцуулбал) харуулсан.

Хүснэгт 1: Сонгосон болон судалгаанд хамруулсан хэргүүд, нийслэлийн дүүргүүдээр

Улаанбаатар хотын дүүргүүд	Хэрэгсэхгүй болгосон	Зөрчлийн хэрэг	Эрүүгийн хэрэг
Сүхбаатар	10	10	20
Баянгол	10	10	20
Баянзүрх	12	10	20
Чингэлтэй	10	10	15
Хан-Уул	10	10	15
Сонгинохайрхан	12	10	20
Нийт	64	60	110

²¹ Хуулийн дараах заалтын дагуу хэрэг үүсгэсэн хэргүүдийг судалгаанд хамруулсан: Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл – Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл – Гэр бүлийн хүчирхийлэл, Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл – Хүндрүүлэх нөхцөлтэйгөөр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн хүнийг алах, Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйл – Хүндрүүлэх нөхцөлтэйгөөр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн бусдад хүнд гэмтэл учруулах, Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйл – Хүндрүүлэх нөхцөлтэйгөөр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн хүндэвтэр хохирол учруулах, Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйл – Хүндрүүлэх нөхцөлтэйгөөр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн хөнгөн хохирол учруулах, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл – Хүндрүүлэх нөхцөлтэйгөөр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн хүчиндэх.


Судалгаанд сонгон авсан хэргүүдээс 32% нь ил харагдах гэмтэл учруулалгүй гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, 32% нь хөнгөн гэмтэл учруулсан, 18% нь хүндэвтэр болон хүнд гэмтэл учруулсан хэргүүд байв.

Фокус бүлгийн хэлэлцүүлэг

Гэр бүлийн хүчирхийлийн тохиолдлыг шийдвэрлэх арга ажиллагаа, туршлагад гарч буй хандлагын талаар мэдээлэл цуглуулах зорилгоор фокус бүлгийн хэлэлцүүлгийг мөрдөгч, прокурор, өмгөөлөгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарыг оролцуулан хийсэн.


Нийт 3 удаагийн фокус бүлгийн хэлэлцүүлэгч нийт 45 оролцогч хамрагдсан. Хэлэлцүүлгийн бүлэг нэг бүрд 4 мөрдөгч, 3 прокурор, 1 шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, 3 өмгөөлөгч багтсан ба эдгээр оролцогчдыг нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдээс тусгайлан сонгон оролцуулсан. Хэлэлцүүлэгт оролцсон бүх оролцогч нь эрх зүйн чиглэлээр дээд боловсролтой оролцогчид байв. Оролцогчдын дийлэнх нь буюу 49% нь 30 болон үүнээс дээш насны оролцогчид байсан бол фокус бүлгийн 98% нь 25-40 насны оролцогчдоос бүрдсэн. Эрэгтэй оролцогч эмэгтэйчүүдээс арай илүү буюу 60 болон 40 хувийн харьцаатай байв.

Зураг 1: Фокус бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчдын мэдээлэл, хүйс



■ Эрэгтэй ■ Эмэгтэй

Зураг 2: Фокус бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчдын мэдээлэл, нас



■ 25-30 ■ 30-35 ■ 35-40 ■ 40-45

Фокус бүлгүүд нь дараах асуудлууд дээр төвлөрөн ажилласан:

- a) Монгол Улсад үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн цар хүрээ;
- b) Мөрдөн байцаалтад тулгарч буй сорилтууд;
- c) Хуулийн хэрэглээ;
- d) Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ;
- e) Аюулын зэргийн үнэлгээ хийх;
- f) Хамтарсан баг;
- g) Хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагаа;
- h) Ял ногдуулах, шийтгэл (торгууль, албадан сургалт болон хорих ял).

Эдгээр арга зүйг хослуулан ашиглан хийгдсэн судалгааны үр дүнг нэгтгэн, дараах бүлэг дээр харуулсан.

ҮР ДҮН

Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдан, хүчин төгөлдөр хэрэгжих эхэлснээс хойш цагдаагийн байгууллагад бүртгэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн нийт тоонд томоохон өөрчлөлт гаралагүй байна. Харин ч цуглувсан баримт нотолгоогоор бүртгэлтэй гэмт хэргийн тоо буурсан харагдаж байна (Хүснэгт 2 дээр үзнэ үү). Шинэ хууль батлагдсан, хамаарах тоо баримтыг 2017 оноос цуглувж эхэлснээр хийгдэж буй судалгаанд гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн хэргийг хамруулах боломжтой болсон. Шинэчлэн найруулсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдахаас өмнө олон тооны хэрэг, зөрчлийг гэр бүлийн хүчирхийлэл хэмээн бүртгэлгүйгээр танхайрах гэсэн зүйл ангид хамруулж байжээ. Тиймээс энэхүү гэмт хэргийн талаар хууль батлагдахаас өмнөх цаг хугацаанд хамаарах мэдээлэл байхгүй.

Цагдаагийн газрын хүлээн авсан дуудлага, мэдээллээр тогтоосон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг

Хүснэгт 2: Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл, 2014-2018

	2014	2015	2016	2017	2018
Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг (эрүү)	1,076	1,356	1,449	1,286	1,070
Бүртгэгдсэн зөрчлийн хэрэг (зөрчил)			Зөрчлийн хууль гараагүй байсан	4,369	5,821

Зөрчлийн тухай хуулиар (5.4 дүгээр зүйл, Заалт 4) тухайн хэргүүдийг гэр бүлийн хүчирхийллийн зөрчил хэмээн үзэх болсноор цагдаагийн байгууллагын хүлээн авч буй гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн ноцтой байдлын талаар илүү нарийвчилсан дүр зургийг гаргах боломжтой болоод байна. Энэхүү шинжилгээнд “бүртгэгдсэн” хэмээн заасан нь цагдаагийн газарт ирсэн дуудлагыг заасан бөгөөд

хэргийг зөрчлийн эсвэл эрүүгийн хэмээн зүйлчилсэн нь мөрдөн байцаалтын явцаас хамааран өөрчлөгдж болно. Дээрх тоон мэдээлэл нь хэрэг нэг бүрийг дуудлага мэдээлэл авсан даруйд хэрхэн зүйлчилсэн болохыг харуулж буй.

Бүртгэгдсэн гомдол, мэдээллийн талаарх статистик мэдээлэл

Шинээр батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хамаарах өгөгдөл мэдээлэл зөвхөн 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хойш гарах боломжтой бөгөөд судалгаанд тухайн хугацаанаас хойш 2019 оны 3 дугаар сарын 31-нийг хүртэлх өгөгдөл мэдээлэл хамрагдсан. Харамсалтай нь сар тутмын мэдээлэл байхгүй. Ажиглалт судалгаа хийсэн хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн нийт 33,425 гомдол мэдээлэл (31,690 зөрчлийн, 1,735 эрүүгийн) бүртгэгджээ. Жил бүрээр сарынх нь дунджийг (Хүснэгт 3 дээр үзнэ үү) харвал зөрчил хэмээн ангилагдсан хэрэг огцом өсөлттэй байна. 2017 оноос 2019 оны хоорондын боломжит мэдээллээс харвал эрүүгийн хэргийн бүртгэгдсэн тоо бараг хоёр дахин нэмэгдсэн бол тухайн хугацаанд зөрчлийн хэргийн тоо гурав дахин нэмэгджээ. Үндсэндээ зөрчлийн хэрэг судалгаанд хамрагдсан бүх хэргийн 95%-ийг эзэлж байна.

Өмнө дурдсанчлан гэр бүлийн хүчирхийллийн хэргийг үйлдсэн нөхцөл байдал, үйлдсэн хэмээн гомдол мэдээлэл өмнө нь ирүүлсэн тооноос нь хамааруулан зөрчил эсвэл гэмт хэрэг хэмээн зүйлчилж болно. Доорх хүснэгтэд судалгааны хамрах хугацаанд бүртгэгдсэн бүх дуудлага мэдээллийг зөрчил эсвэл эрүү хэмээн анхлан бүртгэнээр нь ангилан харуулсан. Дуудлага мэдээлэл хүлээн авч, мөрдөн байцаалтын үйл ажиллагааг явуулсны дараа хэргийн зүйлчлэл өөрчлөгдж болохыг анхаарна уу. Судалгаанд хамрагдсан хугацаанд эрүүгийн болон зөрчлийн хэргийн харьцаа нь харьцангуй тогтвортой байж, мөрдөн байцаалтаас өмнөх шатны зөрчлийн хэрэг 94% болон 96.5%-ийг эзэлж байв.

Хүснэгт 3: Дуудлага мэдээллийн сарын дундаж тоо, зөрчил болон гэмт хэрэг, сарын дундаж, оноор²²

Сарын дундаж

дуудлага, мэдээлэл,

зөрчил болон эрүү

	2017	2018	2019	Дундаж
Зөрчил	937	1,45	2,874	95%
Эрүү	59	8	106	5%
<i>Нийт сарын дундаж</i>	<i>996</i>	<i>1,54</i>	<i>2,980</i>	<i>100%</i>

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт дуудлага, мэдээллээс дунджаар 84% нь нийслэлд, 16% нь аймгуудад бүртгэгдсэн ба судалгаанд хамаарах хугацааны туршид энэхүү хувь хэмжээ харьцангуй тогтвортой байна. Аймгуудад бүртгэгдэж буй хэрэг 14%- 17%, нийслэл бүртгэгдэж буй хэрэг 83%- 86%-ийн хооронд хэлбэлзэж байв.

Хүснэгт 4: Улаанбаатар хот болон аймгууд дахь сар бүрийн дуудлага мэдээллийн дундаж тоо, сарын дундаж, жилээр²³

Сар бүрийн дундаж

дуудлага, хот болон

хөдөө	2017	2018	2019	Дундаж
Улаанбаатар	858	1,273	2,537	84%
Аймгууд	13	269	443	16%
<i>Нийт сарын дундаж</i>	<i>871</i>	<i>1,542</i>	<i>2,980</i>	<i>100%</i>

²² 2017 оны эхний 6 сар болон 2019 оны сүүлийн 9 сарын мэдээлэл дутуу байсан ба зөвхөн 2018 оны мэдээлэл бүтнээр олдсон. Тиймээс тоон үзүүлэлтүүд нь тухайн мэдээлэл бүхий саруудад үндэслэн дундажлан илэрхийлэгдэж, бүрэн хэмжээнд төлөөлөхгүй байж болно.

²³ Зүйт 25 дээр үзнэ үү.

Зөрчил

Судалгааны хамаарах хугацаанд буюу 2017 оны 7 сарын 1-ээс 2019 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн хооронд цагдаагийн газрын хүлээн авсан гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн дуудлагын 2% дээр нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийгдэж байсан тул доорх шинжилгээнд

хамруулаагүй. Харин үлдэх 98%-иас (30,915) 30% нь зөрчлийн хэргээр зүйлчлэгдэн шийдэгдэж, 68% нь хэрэгсэхгүй болж, 2%-ийг зөрчлийн өөр зүйл ангиар зүйлчлэн шалгаж, 36 хэргийг (0.1%) бусад байгууллагад шилжүүлжээ. Нөгөө талаар энэхүү хугацаанд үүссэн эрүүгийн нийт хэргийн 34%-ийг хэрэгсэхгүй болгожээ (Доорх Зураг 3 дээр үзнэ үү).

Судалгаанд хамрах хугацаанд улсын хэмжээнд нийт 9,677 зөрчлийн хэрэг нээн, Зөрчил шалган шийдвэрлэх нэгж шалган шийдвэрлэжээ. Үүнд анхлан Эрүүгийн хэрэг хариуцсан нэгжээс шалгаж эхэлсэн ч улмаар зөрчлийн хэрэг болгон шилжүүлсэн хэргүүд багтсан ба эдгээр нь ойролцоогоор 439 хэрэг буюу нийт хэргийн 1%-тай тэнцэж байна. Хэрэгсэхгүй болгосон хэргүүдийн 68% дээр дүн шинжилгээ хийж үзэхэд нийт хэргийн 99%-ийг Зөрчлийн тухай хуулийн 1.9 дүгээр зүйл, 1.1 дүгээр заалтад заасан шинжийг хангаагүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болжээ.

Зураг 3. Зөрчлийн хэрэг, шийдсэн байдал

ГБХ-ийн бус, зөрчлийн хэргээр шийдэгдсэн, 2%



Байршил

Зөрчлийн хэрэг үүсгэн албан ёсоор шийдвэрлэсэн нийт 9,677 гэр бүлийн хүчирхийллийн хэргийн 58.9% нь нийслэлд, 41.1% нь аймгуудад үйлдэгджээ.

Нийслэлийн хэмжээнд нийт хэргийг 49.6% нь Баянзүрх дүүрэгт, 12.2% нь Хан-Ул дүүрэгт, 9-9.5% нь Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан дүүргүүдэд тус тус бүртгэгджээ. Багахангай дүүрэгт ямар ч тохиолдол бүртгэгдээгүй байна. Орон нутагт үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлыг авч үзвэл хамгийн өндөр нь Төв (13.8%), Орхон (11.2%), Сэлэнгэ (10%), Хэнтий (9.6%) аймгуудад бүртгэгджээ.

Зөрчил шалган шийдвэрлэсэн байдал

Судалгаанд хамаарах хугацаанд МКХ нь зөрчил хэмээн зүйлчлэгдсэн хэргүүдийн дөнгөж 68.6% нь буюу нийт 9,677 хэргийн 6,640 нь шийдэгдсэн буйг тогтоосон. Эдгээр хэрэгт нийт 135 удаагийн торгууль (2%), 6,505 баривчлах (98%) ял ногдуулсан нь хамаарах жилүүдэд ногдуулсан нийт торгох болон баривчлах шийтгэлийн хувь харьцаанаас багахан ялгаатай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг

Судалгаа нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг дээр төвлөрөн судалсан бөгөөд судалгаагаар 2017 болон 2018 онуудад үйлдэгдсэн нийт хэргийн 6%, 2019 онд үйлдэгдсэн хэргүүдийн 4%-ийг хамран хийгдсэн. Анхлан

ирж, гэмт хэрэг зүйлчилсэн 1,735 дуудлага, мэдээллээс 1,669 хэргийг үргэлжлүүлэн мөрдөн байцаалтад шилжүүлсэн нь тухайн хэргүүдийн 96% болж байна. Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд 66 хэрэг буюу 3.8% нь мөрдөн байцаалтын шатанд байсан. Судлаачдын зүгээс нийт хэргийн 62.7% дээр ял ногдуулж, 34.1% нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болж, 1 хүрэхгүй хувь дээр нь (0.3%) өөр ажилтанд шилжүүлэн шалгуулсныг тогтоосон.

Анхаарууштай нь шийдэгдээгүй хэргийн тоо 2017 онд хамгийн өндөр байсан ч тухайн жилийн хамаарах мэдээлэл бүрэн бус байв. 2017 оны сүүлийн 6 сарын хугацаанд 55 хэрэг шийдэгдээгүй байсан нь тухайн үед дөнгөж батлагдаад байсан хуулийг ойлгох, тайлбарлахад хүндрэлтэй байснаас үүдсэн байж болно.


Байршил

Бүхий л хэрэг дээр хот болон хөдөөгийн ялгаатай байдал байдаг, нийт хэргийн 85% нь Улаанбаатар хотод үйлдэгддэг бол гэр бүлийн



хүчирхийллийн гэмт хэргийн 59% нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдэж байна. Эдгээр хэргийн дийлэнх нь буюу 33% нь Баянзүрх дүүрэгт үйлдэгдсэн ч 2019 оны эхний гурван сард бүртгэгдсэн нийт хэргийн талаас илүү нь Баянзүрх дүүрэгт бүртгэгджээ. Судалгаанд хамрагдсан нийт хугацааны дунджаар авч үзвэл хэргийн 20% нь Сонгинохайрхан дүүрэгт, 13% нь Баянгол дүүрэгт, 12% нь Хан-Уул дүүрэгт үйлдэгджээ.

Зураг 2: Эрүүгийн хэргүүд, дүүрэг болон оноор, Улаанбаатар




Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр 2019 оны байдлаар Баянгол дүүрэг нь нийслэл дэх хүн ам хамгийн шигүү суурьшсан дүүрэг бөгөөд хоёрдугаарт орж буй дүүргээс хүн амын нягтаршлын хувьд 4 дахин илүү байна.²⁴ Улаанбаатар хотод үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн

²⁴ Сумдын хүн амын нягтаршил, Үндэсний Статистикийн Хороо, 2019, 1212.mn.

тохиолдол нь хүн амын нягтаршлын хувьд 5, 6, 1 болон 4 дүгээрт орж буй дүүргүүдэд үйлдэгдэж буй тул хүчирхийлэл нь хүн амын суурьшилтай шууд хамааралгүй байна.

Нийслэлээс бусад газруудын хувьд гэр бүлийн хүчирхийллийн хамгийн өндөр тохиолдол Сэлэнгэ болон Өвөрхангай аймгуудад 90 болон 89 хэрэгтэй буй нь хөдөө орон нутаг дахь нийт тохиолдлын 10%-тай тэнцэж байна. Зураг 6 дээр харуулсанчлан үлдэх хэрэг нь (бусад аймаг) нийт хэргийн 2- 8%-ийг эзэлж, судалгаанд хамрагдах хугацаанд нэг аймагт дунджаар 42 хэрэг үйлдэгджээ.

Зураг 6: Эрүүгийн хэргүүд, аймгаар, шинжилгээний хамаарах нийт хугацаанд



Доорх Хүснэгт 5 дээр харуулсанчлан аймгуудад үйлдэгдэж буй гэмт хэрэг нь 37.3%-иас 44.7%-ийн хооронд жил тутамд хэлбэлзэж, 2018 онд хөдөө орон нутагт үйлдэгдсэн хувь хэмжээ хамгийн өндөр байна.

Хүснэгт 5: Хот болон хөдөөд үйлдэгдэж буй гэмт хэргүүд, оноор

	Улаанбаатар	Аймгууд
2017 (7-12 сар)	62.7%	37.3%
2018	55.1%	44.7%
2019 (1-3 сар)	60.9%	39.1%
Нийт	58.6%	41.4%

Үйлдэгдсэн гэмт хэргийн дийлэнх нь (85%) гэр, орон байранд үйлдэгдсэн болохыг баримтжуулсан байна. Цагдаагийн мэдээллээс (гэмт хэрэг үйлдсэн байршил нь гэр болон гудамж зэрэг давхардсан байршлыг зааж болно) үзүүл нийт хэргийн 6.5% нь нийтийн эзэмшлийн гудамж талбайд, 4% нь "бусад" хэмээн тэмдэглэгдсэн газруудад үйлдэгдсэн бөгөөд эдгээрийг тодорхой заагаагүй байна.

Хүснэгт 6: Гэмт хэрэг үйлдэгдэж буй байршил, жилээр

Байршил	2017	2019			% Нийт
	(7-12 сар)	2018	(1-3 сар)	Нийт	
Орон гэр (гэр, байшин, орон сууц)	479	923	427	1,829	85.0%
Гудамж талбай	52	62	27	141	6.5%
Олон нийтийн газар, барилга	18	22	13	53	2.5%
Нийтийн тээвэр	1	0	0	1	0.0%
Төрийн байгууллага	5	6	1	12	0.6%
Ажлын байр	14	13	4	31	1.4%
Бусад	28	44	14	86	4.0%
Нийт	597	1,070	486	2,153	100%

Гэмт хэргийн шинж

Энэхүү судалгаанд хамаарах хугацаанд улсын хэмжээнд нийт 17 хүний амь нас хохирч, гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэйгээр 8 хүн амия хорлосон тохиолдол дээр амия хорлоход хүргэсэн гэсэн үндэслэлээр эрүүгийн гэмт хэрэг үүсгэн шалгажээ. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 1.2%-д нь хүний амь нас үрэгдэж, 91%-д нь бие махбодын гэмтэл учирч, 5.5%-д нь бэлгийн хүчирхийлэл үйлдэгдэж, 1 хүрэхгүй хувь нь хүүхдийн эсрэг үйлдэгджээ.

Хүснэгт 7 дээр харуулсанчлан нэг хэрэгт хэд хэдэн зүйлчлэлээр яллагдагчаар татах боломжтой юм. Жишээ нь эцэг, эх нь насанд хүрээгүй хүүхдэд бие махбодын гэмтэл учруулсан тохиолдлыг гурван шинжээр нь зүйлчлэх боломжтой бөгөөд үүнд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд, насанд хүрээгүй этгээдийн эсрэг гэмт хэрэг болон бие махбодын гэмтэл учруулах гэсэн шинжийг харгалзаж болно.

Хүснэгт 7: Гэр бүлийн хүчирхийллийн хамааралтай гэмт хэргийн зүйлчлэл

Гэмт хэргийн зүйлчлэл	2017 (7 сарын 1- 12 сарын 31)	2018	2019 (1 сарын 1- 3 сарын 31)	Нийт
Амьд явах эрхийн эсрэг гэмт	5	12	8	25
Хүнийг алах	4	7	6	17
Санамсаргүй алах	1	0	0	1
Амия хорлох нөхцөл байдалд	0	5	2	7
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт	528	996	433	1957
Хүнд хохирол учруулах	3	15	6	24
Хүнд хохирол болгоомжгүйгээр	1	0	1	2
Хүндэвтэр хохирол учруулах	16	22	9	47

Хөнгөн хохирол учруулах	310	749	228	1287
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	198	210	189	597
Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	31	40	29	100
Хүчиндэх	31	38	28	97
Бэлгийн дур хүслээ ёс бусаар	0	2	1	3
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	2	4	3	9
Хүн худалдаалах	1	0	0	1
Заналхийлэх	1	4	3	8
Хүүхэд, насанд хүрээгүй этгээдийн эсрэг гэмт хэрэг	2	7	2	11
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	3	1	0	4
Бусад	18	0	0	18
Нийт				2,124*

*Хэргүүдийг нэг эсвэл олон тооны үйлдлээр нь зүйлчилж буй тул зарим нь хоёр эсвэл гурав дахин тоологдсон байх магадлалтай.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын хүн ам зүйн мэдээлэл


Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын хүн ам зүйн мэдээллийг гаргах зорилгоор ЦЕГ-ын Судалгааны төвөөс цагдаагийн бүх газар, хэлтсүүдийн нэгтгэсэн мэдээллийг авсан.²⁵ Хүн ам зүйн мэдээллээс гарсан хамгийн чухал ач холбогдол бүхий үр дүнгийн нэг нь гэр бүлийн

²⁵ Энэхүү мэдээллийн сан нь прокурор дээр буй мэдээллийн сангаас бага зэрэг ялгаатай тоон мэдээлэл агуулж буй бөгөөд учир нь хэргийг зөрчил болгон зүйлчлэх, хэрэгсэхгүй болгох эсвэл хаах тохиолдолд хоёр мэдээллийн санд шинэчилсэн мэдээлэл орж байхаар боловсруулагдсан оршино. Тоон мэдээлэл нь бүрэн төлөөлөхүйц эсвэл эцсийн мэдээлэл бус байж болно.

хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хүүхдүүд болон өндөр настнуудын тоо байна. Статистик мэдээллээс үзэхэд 109 хохирогч 8-17 насын хүүхэд (нийт хохирогчдын 5.85%), үүний 1.3% нь 7 хүртэл насын хүүхдүүд байна. Судалгааны хугацаанд хамрагдсан хохирогчдын 4.8% нь тэтгэврийн хүмүүс буюу 55-аас дээш насын эмэгтэйчүүд, 60-аас дээш насын эрэгтэйчүүд байв.

Эмэгтэй болон эрэгтэй хохирогчдын жендерийн зөрүү нь 18- 49 насын эмэгтэйчүүд дээр үнэмлэхүй өндөр буюу эмэгтэйчүүд 97%-ийг эзэлж буй бол нийт дүнгээр эмэгтэйчүүд 45-60% нь байна. Зөвхөн 7-оос доош насын хохирогчдын дунд эрэгтэйчүүд өндөр буюу 55% байна.

Хүснэгт 8: Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид, нас болон хүйсээр



Мэдээлэл цуглуулах хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн нийт 1,522 хохирогчийн хүн ам зүйн мэдээлэл олдсон. Эдгээр хохирогчдын 1,407 нь эмэгтэй, үлдэх 115 нь эрэгтэйчүүд (92:8) байв. Дүн шинжилгээ хийх хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч насанд хүрэгчдийн дунджаар 48% нь эрхэлсэн ажилгүй, 17% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг,

8% нь оюутан, 6% нь малчин хэмээн бүртгэгдсэн хүмүүс байв.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгчийн хүн ам зүйн мэдээлэл

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн хүн ам зүйн мэдээлэл дээр хийсэн дүн шинжилгээгээр яллагдагчдын дийлэнх нь хохирогчийн нөхөр (43.2%), 15.1% нь хамтрагч, 4 илүү хувь нь авв нь байсныг харуулсан. Үлдэх хэсэг нь эх, хойд эцэг болон өргөмөл хүүхдүүд байна. Судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эмэгтэй хүүхэд тогтоогдоогүй ч судалгааны хүрээнд хамруулсан бусад багц өгөгдөл буй "бусад" хэмээх ерөнхий ангилал нь хүчирхийлэл үйлдэгч болон хохирогч хоорондын хамаарлыг нарийн тогтооход төвөгтэй байдал үүсгэсэн.


Хүснэгт 9: Хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн хамаарал, Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг

Хохирогчтой хамаарах хамаарал Хувь

Гэр бүлийн хүн (Нөхөр)	43.2%
Бусад	28.0%
Хамтран амьдрагч	15.1%
Эцэг	2.4%
Хойд эцэг	2.2%
Хүү	2.0%
Гэр бүлийн хүн (Эхнэр)	1.6%
Ах дүү	1.5%
Хамаатан	1.1%
Хүргэн	1.0%

Дунджаар авч үзвэл хүчирхийлэл үйлдэгчдийн 9% нь бага, 18% нь бүрэн бус дунд, 48.1% нь бүрэн дунд, 3.9% нь мэргэжлийн, 16.7% нь дээд боловсролтой буй бол 4.4% нь боловсрол эзэмшээгүй хүмүүс байна.

Хүснэгт 10: Гэр бүлийн хүчирхийлийн гэмт хэрэг үйлдэгчид, нас болон хүйсээр



Кейс (хавтасст хэргийн) судалгаа: Фокус бүлгийн хэлэлцүүлэг, хэргийн дүн шинжилгээ – Хуулийн хэрэгжилт дэх орхигдол, хийдэл Хуулийн талаарх ойлголтод гарч буй асуудлууд

Монгол Улсын Дээд шүүхээс Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд даасан “байнга, давтан” үйлдсэн үйлдлийг гэр бүлийн хүчирхийлийн бүрэлдэхүүн бүхий үйлдлийг гурав эсвэл дээш тооны давтамжтай үйлдэх хэмээн тайлбарлажээ. Гэр бүлийн хүчирхийлийн зөрчлийн 60 хэрэгт хийсэн шинжилгээгээр эдгээр гэр бүлийн хүчирхийлийн бүх үйлдлийг Эрүүгийн хуульд заасан байнга үйлдээгүй хэмээн тооцож бүх хэргийг зөрчил хэмээн буруу зүйлчилснийг тогтоосон. Гэмт хэргийн хувь хэмжээнээс харвал нийт анх удаа үйлдэгчдийн 52%, дахин үйлдэгчдийн 35, гурав дахь удаа үйлдэгчдийн 13%-д баривчлах шийтгэлийг ногдуулжээ.

Зөрчил болон гэмт хэрэг

Фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын дунд зөрчил эсвэл гэмт хэрэг болох талаар төөрөгдөл үүсэн, талууд харилцан нэг нэгнээ буруутгаж байв. Нэг жишээ нь хэрэг бүртгэгч нарын зүгээс мөрдөгчдийг, мөрдөгчид нь хэрэг бүртгэгчдийг буруутгаж байв. Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдын зүгээс гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн талаарх тайлбар нь хэргийг буруу зүйлчлэхэд хүргэж, хохирогчдод эрсдэл учруулж байна. Хэргийн зүйчлэлийн ийнхүү алдаатай хийж буй нь хүчирхийлэл үйлдэгчийн талаарх өмнөх мэдээлэл зэрэг байнга үйлдэг болохыг харуулах, байнга үйлдсэн болохыг тайлбарлах ач холбогдол бүхий үйл баримт, нотолгоог харгалзахгүй орхиход хүргэж байна. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил болон гэмт хэргийг яланг салгах процедур нь хохирогчдын хувьд аз туршсан нөхцөл байдлыг үүсгэж байна.

Фокус бүлгийн хэлэлцүүлгээр мөн гэр бүлийн хүчирхийллийн хэргийн мөрдөн байцаалтын явцад, ялангуяа хэргийг зөрчлөөс гэмт хэрэг болгон зүйлчлэн шалгахад тулгарч буй гол саад тогторуудыг тогтоон гаргасан.

Мөрдөн байцаалтад тулгарч буй саад тогторууд

Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон цагдаагийн алба хаагчдын зүгээс гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг зөв зохистой мөрдөн шалгахад тулгардаг хэд хэдэн асуудлыг, жишээ нь хаяг буруу байх, холбогдогчийг олж тогтоох боломжгүй байх, хохирогчийн зүгээс гомдлоо татах хүсэлт гаргах зэрэг саад тогторуудын талаар дурдсан.

Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын зүгээс гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр хийгдэж буй сургалтын чанар муу, хангалттай бус, шаардлагатай мэдээллийг сургалтаар өгдөггүй хэмээн үзэж байна. Хэлэлцүүлгээр мөн анхан шатан дахь мөрдөгчдийн хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах мэргэжлийн ур чадвар, мэдлэг хангалтгүй байдаг нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн ихэнхийг хэрэгсэхгүй болгоход хувь нэмэр оруулж буй томоохон хучин зүйл болохыг тодорхойлон гаргасан. Фокус бүлгийн хэлэлцүүлэг нь мөн мөрдөн байцаалтын явцад институцын

учруулж буй хүндрэл бэрхшээлүүдийг тодруулан гаргасан. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын зүгээс гомдол нэг бүрийг маш их анхаарал хандуулан хүлээн авдаг байна. Удирдлагын зүгээс хэргийн талаар өдөр тутамд танилцуулж, тайлагнаж байхыг шаарддаг тул шалгагдаагүй хэргүүд дээр онцгойлон анхаарал хандуулдаг байна.

Хэрэг хэрэгсэхгүй болгох

Нийслэлийн б дүүрэгт хэрэгсэхгүй болгосон зөрчлийн болон эрүүгийн 64 хэргийг прокурорын архиваас авч, дүн шинжилгээ хийсэн. Эдгээр хэрэгсэхгүй болгосон хэргийн 60% нь эрүүгийн хэрэг, 40% нь зөрчлийн хэрэг байв. Нийт хэргийн талаас доош хувийг (48%) хохирогч гомдоо эргүүлэн татсан болон хохирогчийн зүгээс гомдоо хуульд заасан хугацаанд гаргаагүй зэрэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ.

Хохирогч гомдоо эргүүлэн татах

Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчид гэр бүлийн хүчирхийллийн хэргийг мэдээлэхгүй байх эсвэл хохирогчдын зүгээс гомдоо эргүүлэн татахад нөлөөлж буй хэд хэдэн хүчин зүйлсийг хамтдаа тодорхойлсон:

- Хувийн болон гэр бүлийн нэр хүндэд хор учруулахаас айх;
- Гэр бүл салалтаас эмээх;
- Хүчирхийлэл давтагдана хэмээн айх;
- Гомдлыг хэрэгсэхгүй болгоно хэмээх айдас;
- Гэр бүлийн хүчирхийллийн тухай гомдоор цагдаа арга хэмжээ авахгүй хэмээн айх;
- Дуудлага, мэдээлэл өгсөн хүнийг илчилнэ гэсэн айдас.

Хэрэг: Чингэлтэй дүүрэгт үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч О нь 2016 болон 2017 онуудад цагдаагийн газарт 10 гаруй удаагийн дуудлага өгч байжээ. Энэ хэрэг дээр хамтарсан баг томилогдож, нөхцөл байдлын үнэлгээ хийхээр болсон ч үйл ажиллагаа нь цаг хугацааны хувьд saatсаны улмаас 2017 оны 8 дугаар сард хохирогч амь насаа алжээ

Гомдол хэрэгсэхгүй болгох

Фокус бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчдын зүгээс хохирогч гомдоо буцаан татсанаас үл хамаарах прокурорын зүгээс хэргийг үргэлжлүүлэн шалгах боломжтой хэдий ч “талууд эвлэрсэн” хэмээн зөвтгэж байна. Зарим тохиолдолд илт гэмт хэрэг үйлдэж, гэмтэл учруулсан байхад ч хэрэг хэрэгсэхгүй болгож буй тохиолдол байна. Хэрэг хянан шалгах процедур бүрэн хийгдээгүй эсвэл гомдол нь шалгах зайлшгүй шаардлагатай, эргэлзээтэй зүйлсийг агуулсан байсан ч хэрэгсэхгүй болгож байна.

Хэрэг: 2017 оны 9 дүгээр сард хохирогч “Ц” хуучин нөхөр нь согтуу ирж, зодсон гэсэн гомдол гаргажээ. Хохирогчийн зүгээс мөн хүчирхийлэл үйлдэгчийн бүхий л үйлдлийг тодорхой мэдээлсэн байв. Хүчирхийлэл үйлдэгч нь өмнө нь архидан согтуурсан үедээ олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулж, хүчирхийлэл үйлдэн 15 хоног баривчлах шийтгэл хүлээж байсан, мөн эрүүлжүүлэхэд 4 удаа орж байсан хэдий ч аюулын зэргийн үнэлгээ хийгээгүй, байцаалт аваагүй байна. Зөрчлийн хэрэг нээх хугацаа дууссан гэсэн үндэслэлээр гомдлыг хэрэгсэхгүй болгожээ.

Фокус бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчид аюулын зэргийн үнэлгээ хийхгүй байх нь хэрэг хэрэгсэхгүй болоход хүрдгийг дурдаж байв. Аюулын зэргийн үнэлгээ нь хохирогч болон хүчирхийлэл үйлдэгч нэг дор хамтдаа

байхад учрах аюулыг үнэлдэг. Тийм учраас үнэлгээг хэрэг нэг бүр дээр, маш богино хугацаанд багтаан хийж байх шаардлагатай. Үнэлгээний үр дүнг хохирогчийг хамгаалах арга хэмжээг нэн даруй авах эсэхийг тогтоох үндэслэл болгох ёстой. Цагдаагийн албан хаагчдын зүгээс хэрэг нэг бүр дээр аюулын зэргийн үнэлгээ хийж буй ч гарсан үр дүнг нь хохирогчийг хамгаалах бус харин хэрэг хэрэгсэхгүй болгох үндэслэл болгон ашиглаж байна.

Оролцогчдын зүгээс аюулын зэргийн үнэлгээний маягт нь хэт урт, цаг их авдаг гэж үзжээ. Гэр бүлийн бүх гишүүн маягтыг бөглөх шаардлагатай ба энэхүү удаан хугацаа шаардах ажлаас шалтгаалан олон тооны хохирогч, гэрчүүд маягтыг бүрэн бөглөдөггүй тул хэрэг хэрэгсэхгүй болгоход хүрдэг ажээ.

Ногдуулж буй ял

Үйлдсэн гэмтэй хэргийн ноцтой байдалд болон ногдуулж буй ялын зохицтой байдал

Нэг дүүрэгт үйлдэгдсэн, гэр бүлийн хүчирхийллийн ижил төстэй гэмт хэрэгт ногдуулж буй ял нь ял ногдуулахад ялгаатай буйг харуулж байна. Чингэлтэй дүүрэгт бие махбодын гэмтэл учруулаагүй гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт 1 жил хорих ял ногдуулжээ. Чингэлтэй дүүрэгт үйлдэгдсэн, хөнгөн гэмтэл учруулсан гэр бүлийн хүчирхийллийн өөр нэгэн хэрэг дээр 450,000 төгрөгийн (158 ам.доллар) торгууль ногдуулсан байна. Тиймээс бие махбодын ил харагдах гэмтэл учруулалгүй гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээд нь хөнгөн гэмтэл учруулсан этгээдээс илүү хатуу ялаар шийтгүүлж буй нь гэмтэл учруулсан болон учруулалгүй үйлдсэн гэр бүлийн хүчирхийлэлд ногдуулах ялын ялгаатай бодлого дутмаг, хуулийн хийдэл буйг харуулж байна.

Албадан сургалт

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн хэрэг үйлдэгчдэд 7- 30 хүртэл хоног баривчлах эсвэл 10- 50 цагийн албадан сургалтад хамруулах ялын аль

Нэгийг ногдуулж байна. Хэдийгээр шинэ хуулиар өдөрт 2-оос дээш цагийн албадан сургалтад хамруулахаар заасан ч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид энэхүү сургалтад бүрэн хамрагдсан талаарх баримт нотолгоо олдоогүй.

Дүн шинжилгээ хийсэн 90 хэргийн 82% дээр хүндруүлэх нөхцөлтэй хүчирхийлэл үйлдэж, хөнгөн гэмтэл учруулсан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийг албадан сургалтад хамруулалгүй, нийтэд тустай ажил хийлгэлгүйгээр 450,000 төгрөгөөр (ойролцоогоор 158 ам.доллар) торгох ял шийтгэжээ. Хүндруүлэх нөхцөлтэй, хөнгөн гэмтэл учруулсан тохиолдолд баривчлах болон хорих ял ногдуулаагүй байна.

Энэхүү үр дүнг фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчид мөн баталгаажуулж, албадан сургалт отг хийгдэхгүй буй хэмээн өгүүлсэн. Бодит байдал дээр оролцогчдын ихэнх нь албадан сургалтын талаар ойлголтгүй байсан.

Торгууль

Анхлан боловсруулсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай багц хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд санхүүгийн шийтгэл ногдуулахгүй байхаар заасан байсан ч багц хуулийг батлахдаа торгох шийтгэлийг оруулан баталжээ. Шинжилгээнд хамруулсан хэргүүдийн хувьд нийт 110 хэргийн 90 дээр нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн хөнгөн гэмтэл учруулсан ба эдгээрт торгох шийтгэл ногдуулжээ.

Хүчирхийлэл үйлдэгчид торгууль ногдуулах тохиолдолд энэхүү зардал нь хохирогчийн нуруун дээр ирж байна. Шинжилгээнд хамруулсан эрүүгийн хэргээс 34% дээр нь хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчээс санхүүгийн хувьд хамаарлтай байсныг дурджээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажилтнууд оролцсон фокус бүлэг дээр нэг ажилтан “Торгох шийтгэл ногдуулсан гэр бүлийн хүчирхийллийн хэрэг дээр ихэнхдээ хохирогчид нь өөрийн хувийн данснаас торгуулийг төлж барагдуулдаг” гэж хэлж байв.

Нэг гэмт хэрэгт давхар хариуцлага үл хүлээлгэх зарчмын буруу хэрэглээ

Эрүүгийн хуулийн 11.6-д зааснаар зүйлчлэгдсэн хэргүүдийн 48% нь нэг хэрэгт давхар хариуцлага үл хүлээлгэх зарчмыг зөрчсөн нь тухайн хүчирхийлэл үйлдэгчид гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн болон хөнгөн гэмтэл учруулсанд нь шийтгэл ногдуулжээ. Эдгээрээс Давж заалдаш шатны шүүх гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх болон хөнгөн гэмтэл учруулах нь тусдаа гэмт хэрэг гэж үзэж нэг хэргийг л хүчингүй болгосон ба энэ нь Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйлийн б дээр заасан “нэг гэмт хэрэгт нэг шийтгэл ногдуулах” зарчимтай нийцэхгүй байна. 2018 оны 3 дугаар сард Дээд шүүхээс энэ асуудлаар зөвлөмж гарган энэхүү асуудалд тодруулга хийжээ. Судалгаанд оролцсон нэг прокурорын хэлж буйгаар шүүхийн зүгээс гэр бүлийн хүчирхийлэл хэмээн үзэх “байнга” хэмээх шаардлагад яллах дүгнэлт нь нийцэж байхын тулд нэг жилд гурван удаагийн үйлдэл мэдээлэгдэж, бүртгэгдсэн байх хэмээн шаарддаг байна. Хэрэв гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь тухайн гурван хэргийн нэг дээр нь шийтгэл хүлээсэн бол үүнийг оруулан тоолохгүй ба учир нь хүчирхийлэл үйлдэгч тухайн хэрэг дээр хэдийн шийтгэл хүлээсэн тул шийтгэл ногдуулах нь “давхар буюу хоёр удаа шийтгэж” буй хэрэг хэмээн үздэг байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖҮҮД

- I. **Гэр бүлийн хүчирхийллийн эрх зүйн тодорхойлолт:** "Байнга" үйлдэх нь гэр бүлийн хүчирхийллийн эрүүгийн гэмт хэргийн шинж болохыг заасан тодорхойлолтын талаарх төөрөгдлөлтэй буйгаас үүдэн олон хэргийг зөрчил хэмээн үзэж, хүчирхийлэл үйлдэгчид ногдуулах хариуцлагыг бууруулан, хохирогчдыг эрсдэлтэй нөхцөлд үлдэхэд хүргэж байна.

Монгол Улсын Дээд шүүхээс "байнга үйлдэх" гэдгийг гурав эсвэл түүнээс дээш давтамжтай үйлдсэн, гэр бүлийн хүчирхийллийн бүрэлдэхүүнтэй үйлдэл хэмээн тайлбарлажээ. Энэхүү тайлбар нь хангалттай тодорхой бус, хуулийн нэг мөр хэрэглээг хангахын тулд цаашид улам тодорхой болгох шаардлагатай байна. "Байнга" гэсэн нөхцөлийг Эрүүгийн хууль дахь гэр бүлийн хүчирхийллийн тодорхойлолтоос хасах нь зүйтэй. Зөрчлийн тухай хууль нь гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт ашиглагдахгүй, хангалттай хэмжээнд шийтгэл ногдуулахгүй, гэр бүлийн хүчирхийллийн ноцтой байдлыг харгалзан үзэхгүйд хүргэж байна.

- II. **Хууль зүйн салбарын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн хэргийн тоог бууруулах хүсэл өндөр:** Цагдаагийн газарт ирүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэлтэй нь харьцуулбал хэрэгсэхгүй болгож буй зөрчлийн болон эрүүгийн хэргийн тоо өндөр байна.

Энэхүү судалгаанд хамрагдсан олон тооны хэрэгсэхгүй болгосон хэрэг нь илт гэмт хэргийн шинжтэй, тодорхой гэмтэл учруулсан болохыг харуулж буй ч хэрэгсэхгүй болгосон харагдаж байна. Хэрэгсэхгүй болгосон зарим хэрэг дээр хэрэг шалган шийдэх ажиллагаа дутуу хийгдсэн эсвэл гомдол нь анхаарал хандуулахуйц эргэлзээ бүхий мэдээлэл агуулж байжээ.

Мэргэжлийн ур чадвар, анхан шатанд хэрэг илрүүлэх мөрдөн шалгах боломж хангалттай бус, хуучирсан буйгаас гадна олон тооны хэргүүд талууд эвлэrsэн хэмээх үндэслэлээр хаагджээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хохирогч өөрийн гомдлыг буцаан татсанаас үл хамааран прокурорын зүгээс тухайн хэргийг үргэлжлүүлэх шалгах эрхийг

олгосон хэдий ч талууд эвлэрсэн хэмээн үндэслэл нь хэрэг хэрэгсэхгүй болгосон гол шалгаан байна. Тиймээс мөрдөн байцаагч нарт зориулан хохирогчийн гомдолд үнэлгээ хийх гарын авлага эсвэл шалгах хуудсыг хэрэг бүртгэгч, мөрдөгчдөд зориулан боловсруулан хэрэг хэрэгсэхгүй болгох эсвэл үргэлжлүүлэх шалгах эсэхээ шийдэхэд нь дэмжлэг үзүүлж байхыг зөвлөмж болгож байна.

III. Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын гэр булийн хүчирхийллийн хэрэгт хариу арга хэмжээ авах чадавх. Хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудын гэр булийн хүчирхийллийн хэрэгт хариу арга хэмжээ авах, мөрдөн шалгах ур чадвар, мэдлэг, арга хандлагыг сайжруулан шинэчлэх хэрэгцээ шаардлага байна.

Тиймээс гэр булийн хүчирхийллийн динамик эрчмийг сайтар ойлгохын тулд хамаарах эрх бүхий хүмүүсийг илүү ихээр сургалтад хамруулах шаардлагатай байна. Ингэснээр зүйлчлэл буруу хийгдсэнээс үүдэн хэрэг хэрэгсэхгүй болгох, саад тогтор учрах зэргээс сэргийлэх боломжтой болох юм. Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдын зүгээс хохирогч болон иргэдийн дуудлага мэдээллээс өөрөөр гэр булийн хүчирхийллийн хэргийг илрүүлэх шинэ, шинэлэг арга зам шаардлагатай буй талаар дурдаж байсан. Оролцогчдын зүгээс апликеишн, вэбсайт зэрэг технологи ашиглан хөдөө орон нутагт үйлдэгдэж буй гэр булийн хүчирхийллийг илрүүлж байхыг санал болгосон.

IV. Зөрчлийн тухай хуульд заасан Хүчирхийлэл үйлдэгчийг хамруулах албадан сургалт үр дүнгүй байна.

Фокус бүлгийн хэлэлцүүлэг дээр оролцогчдын зүгээс албадан сургалт үр дүнгүй буй талаар дурдаж байв. Оролцогчдын үзэж буйгаар хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс албадан сургалт үр дүнтэй буй эсэхийг үнэлж дүгнээгүй тул хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд хэрхэн нөлөөлж буй нь тодорхойгүй байна. Нарийвчилсан үнэлгээ хийх замаар эдгээр сургалтуудыг үнэлэн дүгнэж, сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

V. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид **торгууль ногдуулж буй нь хохирогчид шийтгэл болж байна.**

Бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон хүмүүсийн зүгээс ихэнх тохиолдолд хүчирхийлэгчид ногдуулсан торгуулийг хохирогч төлж буйг хэлж байв. Үүнээс үүдэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг давхар шийтгэж, хүчирхийлэгчид ногдуулсан торгуулийг өөрөө төлөхөд хүргэж байна. Хуульд буй энэхүү цоорхойд анхаарал хандуулан, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд торгууль ногдуулахыг зогсоох шаардлагатай байна.

VI. **Хүчирхийллийг зөрчил болон гэмт хэрэг хэмээн ангилан яллах нь ээдрээтэй байдал үүсгэн, Эрүүгийн хуулийн дагуу нэг хэрэг нэг ял ногдуулах зарчмыг ээдрээтэй байдалд оруулж байна.**

Дүн шинжилгээ хийсэн гэр бүлийн хүчирхийллийн хэргүүд болон хүндрүүлэх нөхцөлтэйгөөр хөнгөн гэмтэл учруулсан хэргүүд дээр хүчирхийлэл үйлдэгчийг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн болон хөнгөн гэмтэл учруулсан үйлдэлд нь шийтгэл ногдуулж буй нь нэг гэмт хэрэгт нэг шийтгэл хэмээх зарчимд харшилж байна. Дээд шүүхийн зүгээс гэр бүлийн хүчирхийлэл болон хүндрүүлэх нөхцөлтэйгөөр хөнгөн гэмтэл учруулсан хэрэгт ял оноох зааварчилгаа боловсруулан гаргах шаардлагатай.

VII. **Үйлдсэн хэргийн тувшин, эрүүгийн хэргийн явцаас үл хамааран хохирогчдод аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх боломжийг хангах шаардлагатай.**

Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах хуулийн хүчин төгөлдөр захирамж гаргуулан, хүчирхийлэл үйлдэгчийг хохирогчтой уулзахыг хориглох, хохирогчид түр хугацааны санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хохирогч өөрийн гэртээ ганцаар байх эрхийг олгох зэрэг нь ихээхэн үр дүнтэй байдаг. Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах эдгээр арга хэмжээ нь түргэн хугацаанд аюулгүй байдлыг нь хамгаалан, эрүүгийн хэрэг хянан шийдэхэд шаардлагатай баримт нотолгоог хангахад үр дүнтэй.

2004 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар эрүүгийн хэрэг үүсээгүй байсан ч аюулгүй байдлын арга хэмжээг авхуулах боломжтой байсан бол 2017 оны хуульд зөвхөн Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг дурдаж зааж, иргэний зүгээс хүсэлт гарган аюулгүй байдлын арга хэмжээ авхуулах боломжийг хассан байна. Одоогийн байдлаар эрүүгийн хэрэг нь зөвхөн хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд байгаа үед эсвэл хүчирхийлэл үйлдэгч буруутай нь тогтоогдсон тохиолдолд л аюулгүй байдлын арга хэмжээг авхуулах боломжтой байхаар зохицуулжээ. Арга хэмжээний тоонд хүчирхийлэл үйлдэгчийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлахад төвлөрч, хүчирхийлэл үйлдэгчээс санхүүгийн хувьд хамааралтай хохирогчид хүчирхийллээс зугтах, гэр бүлээ тэтгэхэд шаардлагатай бусад дэмжлэгийг үзүүлэхгүй байна.

2017 оны Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуульд аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ дутмаг буй нь хохирогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахаас илүүтэйгээр аюулгүй байдлаа хангах чиглэлд буй хийдлийг улам нэмэгдүүлсэн байна. Аюулгүй байдлаа ханггуулах захирамж гаргуулах боломжийг нэмэгдүүлж, хохирогчид үзүүлэх тусламжийг өргөжүүлснээр энэхүү хийдлийг шийдэх боломжтой болно.

НОМ ЗҮЙ

Хүний Эрхийн Төлөө Өмгөөлөгчид, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв. Эмэгтэйчүүдийн алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хорооны 63 дугаар хуралдаанд илгээсэн тайлан. 2015.

https://www.theadvocatesforhumanrights.org/uploads/mongolia_cedaw_loi_june_201_5.pdf

Бэгзсүрэнгийн Цолмон, Вероника Мендинзабал Жоффре. "Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн дуу хоолойг үйл ажиллагаа болгох нь: Дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх замаар жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь." Азиин Хөгжлийн Банкны Зүүн Азиийн судалгааны цуврал, дугаар 14 (2018 оны 10 дугаар сар): 1-26. <http://dx.doi.org/10.22617/WPS189587-2>.

Монгол Улсын Хүний эрхийн ТББ-уудын Форум. "Олон улсын хугацаат хяналт (UPR): Зөвлөмжүүдийн хэрэгжилтийн чиглэлээрх дунд хугацааны тайлан." 2018 оны 5 дугаар сар. 1-51.

http://upr-mongolia.mn/images/UPR_Midterm_report_HRF_Jul5_2018Final.pdf.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо. "Сүмдын хүн амын нягтаршил." 2019. 1212.mn.

ЭЗХАХБ (OECD). "Монгол Улсын Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хууль." 2001 оны 1 дүгээр сарын 10.

<https://www.oecd.org/site/adboecdanti-corruptioninitiative/46816723.pdf>.

Лила Сейдман. "Монгол Улсын Их Хурал гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн гэмт хэрэгт тооцон хуульчиллаа." *The UB Post*, 2016 оны 6 дугаар сарын 16.

https://web.archive.org/web/20170422024344/http://theubpost.mn/2016/06/16/mon_golian-parliament-recognizes-domestic-violence-as-a-criminal-offense/.

Монгол Улсын Их хурал. Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга). 2015 оны 12 дугаар сарын 3. Улаанбаатар.

<https://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>.

НҮБ-ын Хүн Амын Сан, 2017 Монгол Улс дахь жендерт сууриссан хүчирхийллийн талаарх үндэсний судалгаа (Улаанбаатар: НҮБ-ын Хүн Амын Сан болон Үндэсний Статистикийн Хороо, 2018).

Венди Зелдин. "Монгол Улс: Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох нь." Олон улсын эрх зүйн монитор (Конгрессын номын сан), 2017 оны 4 дүгээр сарын 12. [https://www.loc.gov/law/foreign-news/article/mongolia-domestic-violence-made-a-criminal offense/#:~:text=12%2C%202017\)%20On%20February%201.September%201%20of%20 that%20year](https://www.loc.gov/law/foreign-news/article/mongolia-domestic-violence-made-a-criminal-offense/#:~:text=12%2C%202017)%20On%20February%201.September%201%20of%20 that%20year).